



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govsumber@audit.gov.mn

2021.08.15 № 51

танай _____-ны № _____-т

“ИЛЧЛЭГ ШИВЭЭ” ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ш.ЧИНБОЛД ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Татгалзсан дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийхээр байсан.

“Илчлэг шивээ” ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд дүгнэлт өгөхгүй. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохистой нотолгоо авах боломжгүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Тус байгууллага нь 2020 оны санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанаас 10 хоног хугацаа хоцроож ирүүлсэн, мөн санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн программ хангамж болон Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтын дагуу бэлтгээгүй, аудит хийхэд шаардлагатай баримт материал, журналуудыг ирүүлээгүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.12, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, Сангийн сайдын 2017 оны “Маягт заавар батлах тухай” 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтуудыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, толилуулга ба тодруулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой байсан.

Гэвч, дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн улмаас санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөд үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авах боломжгүй байна.

003020186



Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА